## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

**(2023 оны жилийн эцэс)**

**БАЙГУУЛЛАГЫН НЭР: УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ**

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллагын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 2 | 2 | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012-12-20 Дугаар 2012.12.20 | 7.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална./7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ: 7.1.1.хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал;7.1.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал; 7.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал. | GMP, GHP болон MNS CAC RCP 39:2011 стандартын дагуу зохистой дадлыг мөрдөж ажиллаж байна.<br>• Хүнсний түүхий эд, туслах материал -Түүхий эд, туслах материалыг боловсруулалтын шугаманд оруулахын өмнө ялган ангилах, гадны биет болон механик хольцоор бохирлогдсон, муудсан, мэдрэхүйн эрхтний үзүүлэлтийн шаардлага хангахгүй байвал үйлдвэрлэлд хэрэглэхийг хориглох, нийлүүлэгч рүү буцаах, устгах зэргээр асуудлыг шийдвэрлэн ажилладаг.<br>• Үйлдвэрлэлийн боловсруулах технологи, шат дамжлага -<br>Чанарын багийн үйл ажиллагаа нь бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, түгээх зэрэг хоол, хүнс үйлдвэрлэлийн бүх үе шатанд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангаН ажилладаг.<br>• Бүртгэл, Баталгаажуулалт- Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэрээс хамааран өөр өөрийн онцлогт тохирсон бүртгэлийг хөтлөн ажилладаг. Үүнд: Эрүүл мэнд ариун цэврийн үзлэгийн бүртгэл, хөргөх төхөөрөмж, хөргөгчний хэмийн бүртгэл, их | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | цэвэрлэгээ ариутгал, халдваргүйжүүлэлтийн бүртгэл, дээжийн бүртгэл, хоол хүнсэнд хийгдсэн температурын бүртгэл, өдөрт хийсэн, бэлтгэсэн хоол, хүнс, илүү гарсан хоол, хүнс, түүнийг устгаж хаясан бүртгэл зэргийг мөрдөн ажиллаж байна<br>• Ажилтны хувийн ариун цэвэр, эрүүл мэндэд тавих шаардлага -Хувийн ариун цэвэр, гар угаах, бээлийг тогтмол хэрэглэж байна.<br>• Бүтээгдэхүүнийг эргүүлэн татах, дахин боловсруулах, устгах- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзсэн тохиолдолд харъяалах хяналтын байгууллага, нийлүүлэгч болон дараагийн шатны үйл ажиллагаа эрхлэгчид урьдчилж утсаар, цахим шуудангаар, эцэст нь албан бичгээр мэдээлж хяналтын байгууллагын шийдвэрээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авч ажилладаг.<br>• 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр АХТ-ийн тасгийн эрхлэгч, халдвар судлаач эмч Ц.Уянга, халдвар судлаач Б. Хулан нар Хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон ажилтны эрүүл мэндийн шаардлага, гадаад үзэмж ёс зүй болон эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулж хоол зүй шим тэжээлийн тасгийн 10 эрүүл мэндийн ажилтнууд сургалтанд хамрагдсан. Дотоод аудитын хүрээнд 2023 оны 1 сарын 17, 3 сарын 16-ны өдөр, 09 сарын 07-ны өдөр нийт 3 удаа хяналт хийгдэж хариу арга хэмжээ авсан. 2023/03/16, 2023/08/09, 21-ны өдөр, 2023/09/08-нд нийт 5 удаа эрүүл зүйн шинжилгээтэй хяналтыг 58 нэр бүхий газраас | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | авч үнэлгээ хийсэн. Эрүүл зүйн хяналтын хүрээнд 8 нэр бүхий газраас орчны эрүүл зүйн шинжилгээг авахад 8/3(37.5%) нянгийн бохирдолттой гарсан. Хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд их цэвэрлэгээ халдваргүйтгэл хийгдсэн. | | | |
| | 3 | | 10.2. Энэ хуулийн 10.1.7-д заасан ажилтанд тавих эрүүл мэндийн шаардлага, үзлэгт хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /10.1.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах/; | Энэ хуулийн 10.1.7 заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04-р сарын 14-ний өдрийн А/145 дугаар тушаалын дагуу Эмнэлгийн Хоол шим тэжээлийн тасгийн ажилтнуудыг жилд 2 удаа (6 сар тутам 1 удаа) Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж байна. | 100 | | |
| 3 | 4 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 Дугаар 2015.09.01 | 11.2. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны А/53 тоот тушаал Автограшын журам батлах тухай журмын хавсралт 1 дээр жолооч нар нь албан үүргээ гүйцэтгэх үед эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж хуудсыг өдөр бүр яаралтай тусламжийн эмчээр хянуулж ажил үйлчилгээндээ явдаг. Түргэн тусламжийн автомашин дотор анхны тусламжийн цүнхний иж бүрдэлтэй бөгөөд түүнд эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалуудтай. Түргэн тусламжийн автомашин нь зориулалтын өвчтөн зөөх дамнуурга, хүчилтөрөгчийн баллон, монитор болон бусад хэрэгсэлтэй. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Түргэн тусламжийн тэргэнд тавигдах бүх шаардлагыг ханган ажиллаж байна. | | | |
| 4 | 5 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай 2016-04-22 Дугаар 2016.04.22 | 7.3. Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэхтэй холбогдох харилцааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна. | Иргэд эмчээ сонгон үйлчлүүлэх эрхээ хэрэгжүүлэх үед үүсэх харилцааг ЭМС-ын 2018 оны А/485, 2021 оны А/813, 2022 оны А/139, А/253, А/424, А/344 тоот тушаалууд, ЭМДҮЗ-ийн 2023 оны 8-р тогтоолын дагуу зохицуулж, дээрхи тушаалуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн ЭМЯ-ны шийдвэрээр иргэдээс 13А маягт шаардахгүй, харъяалал харгалзахгүй тусламж үйлчилгээ үзүүлж байна. | 100 | | |
| 5 | 10 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 15.1.3. Нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах, мэдээллийн сан бүрдүүлэх; (15.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Эмнэлгийн цахим хуудсаар дамжуулан ЭМЯ, ГССҮТ, НЭМҮТ гэсэн эрүүл мэндийн байгууллагаас Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, осол гэмтэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлийн шалтгаан, хүүхдэд ээлтэй аюулгүй орчинг бүрдүүлэх талаар мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулж ажилласан.<br>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үеийн хүүхэд хамгаалал болон эмнэлгийн ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Эмнэлгийн эцэг, эхийн зөвлөл”-ийг Эмнэлгийн захирлын 2023 оны 11 дүгээр сарын А/126 дугаар тушаалаар баталж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/240 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Эмнэлгийн дэргэдэх хүүхдийн цэцэрлэгт нийт 4 бүлэгт 98 эмнэлгийн ажилтны хүүхэд хүмүүжиж байна.<br>2023 онд хүүхдийн тасаг эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны 214 хүүхдэд амбулаторийн болон стационарийн тусламж үзүүлсэн ба 46 нь стационарийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мөн түүнчлэн эмнэлгийн мэргэжилтэн ажилтны 0-2 | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | насны 40 хүүхдийг дархлаажуулалтанд хамруулсан. | | | |
| 6 | 11 | Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай 2017-05-12 Дугаар 2017.05.12 | 14.2.2.. эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтийг хангах; | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний 3 зорилтын хүрээнд 2023 онд 10 үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаа.<br>Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчдэд эх, хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолт болон эмчилгээний хоолны ач тусын талаарх эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэн ажилласан.<br>Эмнэлгийн цахим хуудсаар дамжуулан Эрүүл Мэндийн Яам, Эх, Хүүхдийн Үндэсний Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв гэсэн эрүүл мэндийн байгууллагаас эх, нялх, балчир хүүхдийн эрүүл хүнс, зөв хооллолтыг дэмжих чиглэлээр гаргасан зөвлөмж мэдээллийг цаг тухай бүр нийтлэн цааш түгээн ажилласан. | 100 | | |
| 8 | 15 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | "ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-ний хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахад дараах ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд:<br>• Сувилагч бэлтгэдэг 5 сургуулийн 200 гаруй оюутнуудтай уулзалт зохион байгуулж төгсөх курсийн оюутныг туслах сувилагчаар ажиллуулах санал тавьж 12 туслах сувилагчийг ажиллуулж байна.<br>• 2023 оны 02 дугаар сарын 15 өдөр "Ирээдүйдээ хийх хөрөнгө оруулалт-дархлаажуулалт" сэдвээр Этүгэн их сургууль, Олон улсын Улаанбаатар их сургуулийн төгсөх ангийн сувилахуйн оюутнуудад элэгний В вирусын халдвараас сэргийлэх, В гепатитын дархлаа тогтоцын шинжилгээг 40 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оюутанд хийж 32 оюутанд нэмэлт дархлаажуулалтанд хамруулсан байна.<br>• 2023 оны 10 дугаар сарын 16- ны өдрөөс 11 дугаар сарын 1-ны хооронд томуугийн дархлаажуулалт(GCFLU-Солонгос улсын 4 цэнт вакцин) хийгдэж 600 эрүүл мэндийн ажилтанг хамруулсан. ЭМС-ийн 02 тоот албан даалгаварын хүрээнд сувилахуйн албатай хамтран нийт 14 вакцинатор сувилагч "Аюулгүй дархлаажуулалт" сургалтыг 2023 оны 01 дүгээр сарын 25 өдөр зохион байгуулсан.<br>• ЭМС-ын 2023 оны 4 дүгээр сарын 11 өдрийн 5/1616 чиглэл хүргүүлэх талаар АХТ-ийн 16 ариутгагч угаагч нарыг халдвараас сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулсан. "ОЭТББ-ний халдварын сэргийлэлт хяналт, МТСА-аар үүсгэгдсэн халдварын илрүүлэг деколонизаци" сэдвээр 2023 оны 2 сарын 07-ны өдөр 175 сувилагч тусгай мэргэжилтэнг хамруулан сургалт зохион байгуулсан. Эм зүй хангамжийн албатай хамтран 2023 оны 11 сарын 01-нд 1 багц цагийн сургалт зохион байгуулагдсан.<br>• Сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд өөрийгөө хөгжүүлэх, зорилгоо тодорхойлох, ажлаа дүгнэх арга зүйгээр хангах “Бүтээмжийн хөтөч”-ийг боловсруулан 200 ширхэг хэвлүүлж өгөөд байна. Энэ нь сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн KPI-үнэлгээг хийхэд гарын авлага болно.<br>• Этүгэн их сургуулийн 3-р дамжааны оюутнуудтай багш шавийн гэрээ байгуулж ажлын байранд дасан зохицох сувилагч багшаас суралцах ажлуудыг зохион байгуулаад байна.<br>• Камбуг Самсунг эмнэлгийн туршлагаар шинэ ажилтнуудад эмнэлгийн байршил, сувилагчийн зайлшгүй мэдэх мэдээллийг оруулсан гар самбар | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өгч ажлын байран дээр дасан зохицоход нь дэмжлэг үзүүлж байна.<br>• 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмнэлгийн ажилтан, мэргэжилтний үндсэн цалинг 30%-иар нэмэгдүүлсэн.<br>• Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолын дагуу Эмнэлгийн захирлын 2023 оны 07 дугаар сарын 19-ний А/75 дугаар тушаалаар эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилладаг эмнэлгийн туслах албан тушаалтны цалинг Засгийн газрын тогтоолоор батлагдсан цалингийн доод жишгээс 20%, эмнэлгийн төрийн үйлчилгээний эрүүл мэндийн ажилтны цалинг Засгийн газрын тогтоолоор батлагдсан цалингийн доод жишгээс 10%-иар тус тус нэмэгдүүлж шинэчлэн баталсан.<br>• 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн эмнэлгийн ажилтнуудын автобусыг "Улсын хоёрдугаар төв эмнэлэг-ханын материал чиглэлд явуулж байна.<br>• Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал- Халдварын сэргийлэлт хяналт нэг сарын аян зохион байгуулах ажлын хүрээнд: Ажлын хэсэг гаргаж бүх тасгуудыг оролцуулан 2 чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, үйлчлүүлэгчийн аюулгүй орчин сэдвээр эмчилгээний тасгууд болон дэмжих үйлчилгээний тасгуудын дунд зарлан, тасаг нэгж бүр сургалт зохион байгуулсан. Мөн шинээр ажилд орсон эрүүл эрүүл мэндийн ажилтныг хамруулсан бөгөөд чанар аюулгүй байдал, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр нийт 616 эрүүл мэндийн ажилтанд 7 төрлийн сургалтын хөтөлбөр батлуулж 33 удаа сургалт зохион байгуулсан.<br>• Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилт, Халдвараас сэргийлэх талаар видео шторкны уралдаан зарлаж цахим сүлжээнд байршуулсан. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нийт 12 тасаг уралдаанд оролцсон ба Зүрх судасны тасаг, Бөөр дотоод шүүрлийн тасаг, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба идэвхитэй оролцсон.<br>• 2023 онд Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6-н зорилтын хүрээнд үйлчилүүлэгчдэд зориулсан 6 төрлийн видио шторк Дэмжих сангийн төслийн санхүүжилтээр хийгдсэн. Халдвараас сэргийлэх талаар видео шторк, анимейшны ажил гүйцэтгүүлэх гэрээг 2023 оны 03 дугаар сарын 29 өдөр "Хурд инженеринг" ХХК Irmuun Z production-тай хийгдэж 6 төрлийн 10.97 минутын бичлэг хийгдсэн. Нийт 6 бичлэг 2023 оны 9 дүгээр сарын 18-аас 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл зураг авалтын ажил хийгдэж дууссан. 11 дүгээр сарын 02-оос 11 дүгээр сарын 10 өдрийг хүртэл бичлэгийг засварлаж дууссан. Бичлэгийн сэдэв 1. Мэс заслын аюулгүй байдал (02:45 мин) 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг бууруулах (02:11 мин) 3. Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдал (01:52 мин) 4.Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах (01:32 мин) 5. Үр дүнтэй харилцаа (02:08 мин) 6. Унах эрсдэл (01:52 мин) 7. Хөгжмийн булан (02:05 мин) бичлэгийг хүлээн авсан. Мэдээлэл технологийн албанд хүргүүлж үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсгүүдэд байршуулсан.<br>• Нийгмийн эрүүл мэнд дэмжих зорилгоор нийслэлийн ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн сурагчдад зориулсан 2 өдрийн сургалт, танилцуулах өдөрлөг зохион байгуулагдсан. Нийт 23 эмч мэргэжилтнүүд 1600 хүүхдэд 4 сэдвээр мэдээлэл өгсөн. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу Захиргаа, хүний нөөцийн албаны 5, Мэдээллийн технологийн албаны 2, Ариутгал халдваргүйтгэлийн тасгийн 7, Тусгай тасгийн 7, | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Инженерийн байгууламжийн албаны 11, нийт 5 алба, тасгийн 32 албан тушаал, 58 мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан. (Ерөнхий захирлын 2023 оны А/34, А/38, А/43, А/46, А/52 дугаар тушаал) Дараах нийтлэг зорилтуудыг албан тушаалын тодорхойлолтод тусгасан.<br>. - Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын асуудал, олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын хэрэгжилтийг хангах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэл, ёс зүйг ханган ажиллах<br>. - Албаны үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, хянах, үр дүнг мэдээлэх, тайлагнах<br>. - Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оролцох<br>. - Гамшгийн үеийн бэлэн байдал, амилуулах суурь болон лавшруулсан тусламжийг үзүүлэх<br>. - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын хяналт, сэргийлэлтийн дэглэм, зааврыг мөрдөх<br>. - Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөх<br>. - Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх<br>. - Эрүүл мэндийн даатгал, статистикийн мэдээ, мэдээллийг үнэн зөв, шуурхай гаргах<br>. - Эмнэлэгт шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд мэргэжлийн зайлшгүй шаардлагатай чиг баримжааг таниулах<br>- Авилгын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх<br>• Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны 05 дугаар сарын А/51 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан.<br>• 2023 оны 02 дугаар сард эмнэлгийн нийт ажилтны Хөдөлмөрийн гэрээ шинэчлэн байгуулсан бөгөөд хөдөлмөрийн гэрээнд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэл, ёс зүйн асуудлыг тусгасан.<br>• Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйл “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А/279 дугаар тушаалаар баталсан “Албан нууцын жагсаалт”-ыг үндэслэн эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны 09 дүгээр сарын А/97 дугаар тшаалаар "Байгууллагын нууцыг хамгаалах журам", "Байгууллагын нууцыг хамаарах мэдээллийн жагсаалт", "Нууцын баталгааны хуудас" -ны засварыг тус тус баталсан.<br>• Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/396 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Мэдээллийн ил тод байдлыг хангах журам”-ыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны А/28 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>• "Цахим мэдээллийн нууцлал, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах журам"-ыг эмнэлгийн Ерөнхий захиралын 2022 оны 10 дугаар сарын | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 03-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.<br>• Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны 04 дүгээр сарын А/50 дугаар тушаалаар “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулах албан тушаалтны жагсаалт болон олгох хариуцлагын нэмэгдлийн хувь”, “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загвар”-ыг тус тус баталж, эд хариуцсан албан тушаалтнуудтай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>• Гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх урт хугацааны сургалтанд нийт 13 чиглэлээр 5 улсад 16 эмч, 1 сувилагч, 1 рентген техникч нийт 17 эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. Үүнд бөөрний мэс заслын чиглэлээр 2 эмч АНУ болон Япон улсад, нүдний пластик мэс заслын чиглэлээр 1 эмч Япон улсад, Бөөр судлал чиглэлээр 1 эмч АНУ, тархи нугасны хавдрын чиглэлээр 1 эмч БНСУ-д, хавдрын чиглэлээр 1 эмч Тайваньд, уушги судлал чиглэлээр 1 эмч БНСУ-д, Мэдрэлийн мэс заслын мэдээгүйжүүлэг чиглэлээр 1 эмч Тайваньд, зүрхний мэдээгүйжүүлэг чиглэлээр 1 эмч Тайваньд, мэдрэлийн мэс засал чиглэлээр 1 эмч БНСУ-д, гар сарвууны мэс засал чиглэлээр 1 эмч БНСУ-д, Зүрхний судсан дотуурх оношилгоо эмчилгээний чиглэлээр 2 эмч, 1 сувилагч, 1 рентген техникч БНСУ-д, нүд судлал чиглэлээр 2 эмч БНХАУ-ын ӨМӨЗО-нд, ходоодны уян дурангийн чиглэлээр 1 эмч Япон улсад тус суралцаад байна.<br>• Гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад богино хугацааны сургалт, эрдэм шинжилгээний олон улсын хурал, семинарт 27 чиглэлээр 17 улсад 76 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдсан. Үүнд сэргээн засах эмчилгээ, дүрс оношилгоо, мэс засал, мэдрэлийн мэс засал, хавдар, интервеншл радиологи, ходоодны уян дуран, зүрхний ангиографи, цөмийн оношилгоо, зүрх судас судлал, ортопед, гэмтэл согог, эм зүй, уушги судлал, мэдээгүйжүүлэг судлал, толгой хүзүүний мэс засал, ангиографи, үе судлал, уламжлалт, мэдрэл судлал, яаралтай тусламж, дотоод шүүрэл, сувилахуй, уушги судлал, нүд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, эмнэлгийн тусламж, үйлчилгээ чиглэлээр Франц, Япон, Казакстан, БНСУ, Дани, АНУ, Канад, Тайвань, БНХАУ, ӨМӨЗО, Нидерланд, Тайланд, Хонг-Конг, Итали, БНПортугал, Унгар, Австрали улсуудад богино хугацааны сургалт, олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцсон байна.<br>• Мэдрэлийн мэс засал-1, хүүхдийн мэдээгүйжүүлэг судлал-1, эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал-2, мэдрэл булчингийн бичлэг-3, хүүхдийн эрчимт эмчилгээ судлал-1, гемодиализ-1, дурангийн онош зүй-1, мэдрэлийн хөдөлгөөн засал судлал-1, Тархи судасны хэт авиан доплерографи-2, Тархины цахилгаан бичлэг-2, судсан дотуурх оношилгоо, эмчилгээ-1, эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын менежер-3 буюу 18 эмч, 1 хөдөлгөөн засалч нийт 19 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх дотоодын сургалтад хамрагдсан. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сургалтанд хамрагдах хугацаанд үндсэн цалинг олгосон.<br>• Мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн мэргэшил эзэмших 3-6 сарын дотоодын сургалтад Яаралтай тусламжийн сувилахуй-1, Эрчимт эмчилгээний сувилахуй-7, Мэс заслын сувилахуй-15, хавдрын сувилахуй-2, дурангийн | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | онош зүй-2, мэдээгүйжүүлгийн сувилахуй-2 нийт сувилагч мэргэжилтнийг байгууллагын захиалгаар үүнээс 24 мэргэжилтнийг төрийн сангийн санхүүжилтээр суралцуулсан. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны сургалтанд хамрагдах хугацаанд нь үндсэн цалинг олгосон. | | | |
| 9 | 16 | Донорын тухай /Шинэчилсэн найруулга/ 2018-01-19 Дугаар 2018.01.19 | 11.3.. Донорын цус, цусан бүтээгдэхүүн болон донорын эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний үнийн жишгийг эрүүл мэндийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Донорын цус, цусан бүтээгдэхүүн болон донорын эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээний үнийн жишгийг тогтооход ашиглах эмнэлгийн саналыг илгээсэн. 2023 оны 4-р улирлаас элэг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээ эхлэх төсөл хэрэгжүүлж буй хүрээнд энэ эмчилгээг ЭМД-р санхүүжүүлэхээр сонгон шалгаруулалтад материал өгсөн байгаа. | 100 | | |
| | 18 | | 22.1.. Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, цусаа 35-аас дээш удаа өгсөн донорыг магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Дээрхи журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эмнэлэг нь Донорын холбоотой олон жил хамтран ажиллаж байгаа бөгөөд “Хүндэт донор” иргэдийг эмнэлгийн үйлчлэх хүрээнд бүртгэн авч тогтмол тусламж үйлчилгээ үзүүлдэг. | 100 | | |
| 13 | 29 | Коронавирус халдвар /ковид-19/-ын цар | 7.1.1 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалт тогтоох, зайнаас харьцах зэрэг | 2023 онд гамшигийн үеийн бэлэн байдлыг судалгаанд хувийн хамгаалах хэрэгсэл, эм эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийн судалгааг хийсэн байна. Үүнд 46 нэр төрлийн 96957 эм бэлдмэл, эм эмнэлгийн хэрэгсэл 42 нэр төрлийн 169,517ш | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29 | шаардлагатай арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагын саналыг үндэслэн авах, тэдгээрт мөрдөх журам, зааврыг батлах; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./ | эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн, 11 төрлийн 46,900ш хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн байдлын хангаад байна.<br>Цар тахал, гамшигийн үеийн бэлэн байдлын хүрээнд яаралтай тусламжийн тасгийн тусгаарлах өрөөг байнгын бэлэн байдлын хүрээнд яаралтай тусламжийн тасгийн тусгаарлах өрөөг байнгын бэлэн байдалд байлган тохижуулсан. Тасаг бүрт улаан, шар, ногоон, бүсийн өрөө, хэсгүүдийг тодорхой болгосон. Шаардлагатай тоног, төхөөрөмж, тусгаарлах хаалтуудыг бэлтгэсэн. | | | |
| | 30 | | 7.1.4.. Цар тахлын үед халдварын голомтод болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг шийдвэрлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:) | Цар тахал, гамшигийн үед эмнэлгийн эмч, ажилчдын бэлэн байдлыг хангах зорилгоор 42 нэр төрлийн 169,517ш эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн 11 төрлийн 46,900 хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн байдлыг хангасан. Ариутгал, халдваргүйтгэлийн бодисын 1 сарын нөөцтэй. | 100 | | |
| | 34 | | 7.1.14. цар тахлаас хамааралгүйгээр хийгдэж байгаа бүтээгдэхүүний экспортыг хориглохгүй бөгөөд эм, эмнэлгийн хэрэгсэл, | Эмнэлгийн хэмжээнд цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодис, эм, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, хүнс зэрэг шаардлагатай зүйлсийг нийлүүлэлт болон хэрэглээний үйл ажиллагаанд ямар нэг гомдол гараагүй. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оношлуур, урвалж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, иргэдийн хамгаалах хэрэгсэл, хүнсний болон бусад шаардлагатай барааг улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг шийдвэрлэх; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./ | Тендерийн хуулийн дагуу гэрээ хийгдэж худалдан авах үйл ажиллагаа нийлүүлэлт хийгдсэн. | | | |
| | 35 | | 7.1.15. цар тахлын болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авахад шаардлагатай хүнсний болон бусад нөөцтэй байх ба нөөцийн жагсаалтыг баталж, түүнийг бүрдүүлэхтэй холбоотой 3 сараас доошгүй хугацааны зардлыг шийдвэрлэх; /Энэ заалтад 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./ | Тендерийн хуулийн дагуу хүнсний бүтээгдэхүүн худалдан авах гэрээ хийгддэг ба тухай бүрд нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэлт хийгдсэн. | 100 | | |
| | 38 | | 7.1.21 коронавирусын халдвар авсан, халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, хуульд заасан аргаар таслан зогсоох; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | 2023 оны Коронавируст халдварын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахтай холбоотой эмнэлэгт мөрдөх түр заавар №20 нийт 2 удаа шинэчилэн боловсруулсан. 2023 оны байдлаар Коронанавируст халдвар батлагдсан 9 эрүүл мэндийн ажилтан, 16 үйлчлүүлэгч халдвар авсан байна. Үүнтэй холбоотойгоор нийт 23 тасаг, албадууд халдварын дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангаж ажилласан. Тусгаарлан сэргийлэлтийн дэглэмийг сахиж ажилласан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 40 | | 7.1.23.. цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш хүртээмжтэй хангах; /Энэ заалтыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | 2023 оны Коронавируст халдварын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахтай холбоотой эмнэлэгт мөрдөх түр заавар №20 нийт 2 удаа шинэчлэн боловсруулсан. 2023 оны байдлаар Коронавируст халдвар батлагдсан 9 эрүүл мэндийн ажилтан, 16 үйлчлүүлэгч халдвар авсан байна. Үүнтэй холбоотойгоор нийт 23 тасаг, албадууд халдварын дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангаж ажилласан.<br>2023 оны Томуугийн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахтай холбоотой эмнэлэгт мөрдөх түр заавар №21 гаргаж, шинэчлэн боловсруулсан. 3 чиглэл 26 заалт бүхий томуугийн халдвараас сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | | |
| | 42 | | 9.1.. Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагатай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/36 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2023 оны Коронавируст халдварын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахтай холбоотой эмнэлэгт мөрдөх түр заавар №20 нийт 2 удаа шинэчилэн боловсруулсан. Нийт хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчид болон амбулаторийн тусламж үйлчилгээ авч буй иргэдэд шинж тэмдгийн тандалт хийж сэжигтэй тохиолдолд түргэвчилсэн оношлуураар оношилж байна. | 100 | | |
| | 43 | | 9.3.. Энэ хуулийн 7.1.15-д заасан нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий эд, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон онцгой байдлын асуудал | Эм, эмнэлгийн хэрэгсэлийн 2 сарын урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодисын 1 сарын нөөцтэй. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. /Энэ хэсгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ | | | | |
| 14 | 46 | | 13.3.. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр”- ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ойрын болон хэтийн төлөвлөгөөнд хөгжлийн асуудлыг тусган Эрүүл мэндийн яаманд батлуулахаар хүргүүлсэн. | 100 | | |
| | 47 | | 21.5. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | 2023 оны 11 сарын 08-ны өдрийн 6/5051 тоот албан бичгийн дагуу Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 2023 оны жилийн эцсийн байдлаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу хэрэгжилтийг хүргүүлсэн.<br>• “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн Эрүүл мэнд” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө эрүүл мэндийн сайдын А/760 дугаар тушаал<br>• “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө Эрүүл мэндийн сайдын А/559 дугаар тушаал<br>• “Хавдрын эсрэг” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө Эрүүл мэндийн сайдын А/360 дугаар тушаал<br>• Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө Эрүүл мэндийн сайдын А/523 дугаар тушаал | 100 | | |
| 15 | 48 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн байгууллагын эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны стратеги | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2022.05.01 | | төлөвлөгөө зэргийг боловсруулан ажиллаж байна.<br>1. Байгууллагын эрхэм зорилго: Монгол улсын иргэдийн эрүүл амьдрах, сэтгэл ханамжийг хангаж ажиллах, үйлчлүүлэгч болон ажилчдын орчны аюулгүй байдлыг хангасан, үйлчлүүлэгч төвтэй цогц үйлчилгээг үзүүлэхийг зорин ажиллаж байна.<br>2. А. Үйл ажиллагааны стратегийн зорилго: Олон улсын стандартад нийцсэн, хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээтэй холбоотой стандартуудыг нэвтрүүлж хэрэгжүүлсэн батламж авч, Монгол улсын шилдэг эмнэлэг болох, үйлчлүүлэгчдэд Монгол улсын шилдэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага гэдгээ хүлээн зөвшөөрүүлэх зорилготойгоор ажиллаж байна.<br>Б. Үйл ажиллагааны стратегийн зорилт: Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь олон улсын магадлан итгэмжлэгдсэн байгууллага болох(JCI), гадаадаас үйлчлүүлэгч хүлээн авах, эмнэлгийн гол үйлчилгээг хөгжүүлэх, шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, эмнэлгийн ажилчдыг олон улсын жишигт нийцүүлэн сургах, мэргэшүүлэх, шаардлага хангасан эмнэлгийн орчин нөхцлийг бүрдүүлэх гэсэн 6 гол зорилт тавин ажиллаж байна.<br>3. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ба түүний үр дүн: Байгууллагын өнөөгийн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийснээр, эмнэлгийн цаашдын үр өгөөжтэй ажиллах, байгууллагын хөгжлийн бодлогын хүрээнд шинээр ямар арга хэмжээ, бодлого хэрэгжүүлэх тухай төлөвлөгөө гарган ажилласан.<br>Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийснээр Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн эрхлэх | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | асуудал нь нийт 61 хууль байна. Үүнээс Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах 18 хуулийн хүрээнд салбарын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон.<br>SWOT шинжилгээ хийж, дотоод орчны давуу болон сул тал, гадаад орчны эрсдэл, боломжийг дүгнэн шинжилж цаашид хэрэгжүүлэх эрсдэл боломжийн төлөвлөгөөг нарийвчлан тодорхойлсон.<br>Салбар хоорондын хөгжлийн харилцан уялдаа, бодлого үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах арга замыг тодорхойлж, хүрэх үр дүнг тооцсон бөгөөд зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж цаашдын стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | | | |
| | 49 | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн цахим хуудас болох http://ssch.gov.mn веб сайтын ил тод байдлын цэс нь:<br>● Үйл ажиллагааны ил тод байдал<br>● Төсөв санхүүгийн ил тод байдал<br>● Төлбөр тооцоо<br>● Худалдан авах ажиллагааны ил тод байдал<br>● Хүний нөөцийн ил тод байдал<br>● Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо<br>● Авлигын эсрэг үйл ажиллагаа гэсэн дэд цэснээс бүрдэх бөгөөд эмнэлгийн ерөнхий захирлын тушаалууд, үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө, төсөв, санхүүгийн ил тод байдлын мэдээллүүд, нээлттэй ажлын байрны зар, шаардлагатай утасны жагсаалтуудыг байрлуулан тогтмол шинэчилдэг.<br>Мөн Улсын хоёрдугаар төв эмнэлэг facebook пэйж хуудас, өдөр тутмын үйл ажиллагаа, шинэ мэдээлэл, ажлын байрны зар гэх мэтчилэн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагатай холбоотой мэдээллүүд 24 цаг тутамд шинэчлэгдэн орж байдаг. Түүнчлэн 70150222 гэсэн лавлах утас болон 70150235, эрүүл мэндийн даатгалын 70150211 утсуудаар эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой чанар, аюулгүй байдал, гомдол, санал хүсэлт, талархлыг хүлээн авч, бүх мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>Санхүү төсвийн тухай хуулийн дагуу https://shilendans.gov.mn/ сайтын Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хуудсанд мэдээллүүдийг тухай бүрд нь оруулж ажилладаг. | | | |
| | 50 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Сар бүр шилэн дансны хуулийн дагуу ил тод болгох мэдээллийг хуулийн хугацаанд цахим системд байршуулсан. | 100 | | |
| | 51 | | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эмнэлгийн дотоод хэм хэмжээг батлан гаргах шаардлагатай тул эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/28 дугаар тушаалаар байгууллагын “Мэдээллийн ил тод байдлыг хангах журам”, “Байгууллагын ил тод мэдээлэх мэдээлэл, түүнийг хариуцах нэгж, албан тушаалтны жагсаалт”-ыг баталсан. Байгууллагын ил тод байдлын 2023 оны тайланг хагас жилээр болон бүтэн жилээр гарган ЭМЯ-нд хүргүүлсэн. | 90 | | |
| | 52 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр”- ийн биелэлтийг 2023 оны жилийн байдлаар хийсэн.<br>Үүнд: | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт<br>2.Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт<br>3.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт<br>4.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт<br>5.Хэрэглэгчийн үнэлгээ<br>6.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт<br><br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангаж байна. | | | |
| | 53 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | 1995-2021 онд батлагдсан хүчин төгөлдөр 43 хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 28 тогтоол, Эрүүл мэндийн сайд болон ТЕГ-ын дэд дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, генералтай хамтарсан тушаал, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2002 оны 122-р тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/94, А/193-р тушаал, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2019 оны А/142, А/47-р тушаал, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 116/А565-р тушаал, Эрүүл мэндийн сайд, ХХААХҮС-ын 2022 оны хамтарсан А/255 А/137 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49/118 дугаар тушаал зэрэг хамтарсан 7 тушаал, Эрүүл мэндийн сайдын 127 тушаал, холбогдох дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 100 | | |
| | 54 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ssch.gov.mn домэйн хаягтай цахим хуудасны Танилцуулга хэсэгт бүтэц зохион байгуулалт, хаяг байршил, | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | харилцах утасны дугаар, шуудангийн хаяг зэрэг мэдээллүүд нийтлэгдсэн. https://ssch.gov.mn/articles/show/alban-haagchdyn-medeelel/mn | | | |
| | 55 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд үйлчлүүлэгчид болон эмнэлгийн ажилтнуудаас ирсэн өргөдөл, гомдол, саналыг “Тусламж үйлчилгээний талаар гаргасан өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх тухай УХТЭ-БМ-02 ТҮЖ 1:2018-3” журмын дагуу бүртгэж, шийдвэрлэж ажилласан. ЭМС-ын 2022 оны А/50 дугаар тушаалын дагуу улирал бүр ЭМЯ-д мэдээлсэн. Эмнэлэг өргөдөл гомдол, санал хүсэлтийг 70150206, 70150205 утсаар, эмнэлгийн цахим веб хуудсаар (ssch.gov.mn), эмнэлгийн мэйл хаягаар (info@ssch.gov.mn) хүлээн авдаг. Түүнчлэн эмнэлгийн амбулаторийн хэсгүүдэд нийт 12 ширхэг санал хүсэлтийн хайрцаг байршуулсан. Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн 1 давхар, төв байрны 1 давхарт тус тус талархлын самбар ажиллуулдаг. Мөн ЭМТҮЧАБ-ын албанд иргэдийн санал хүсэлт, гомдлыг ажлын цагаар тогтмол хүлээн авдаг. Өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягыг мэдээллийн самбаруудад ил тод харагдахаар байршуулсан.<br><br>2023 оны жилийн эцсийн байдлаар эмнэлгийн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд нийт 152 өргөдөл гомдол, санал хүсэлт бүртгэгдсэн байна. Үүнээс Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой-36 буюу 23.6%, Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлагатай холбоотой-16 буюу 10.5%, Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой- | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 66 буюу 43.4%, Улирал, цаг үеийн шинжтэй зонхилж багаа асуудал-0, Бусад-34 буюу 22.3% байна.<br><br>1. Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой гомдол нийт 36 буюу 23.6% байна. 1-р улиралд үзлэг, шинжилгээний хүлээгдэл, эрүүл мэндийн даатгалын битүүмж үүссэнтэй холбоотой, эрт илрүүлгийн дурангийн шинжилгээ хүний нөөцийн хомсдолоос үүссэн гомдлууд байсан бол 2-р улиралд амбулаторийн кабинетийн дараалал их, үзлэгийн цагийн дараалал зарим ачаалалтай тасгуудад 1 сараас дээш хугацаатай байсантай холбоотой гомдлууд байсан.<br>2. Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой хүсэлт өргөдөл нийт 66 буюу 43.4% байгаа бөгөөд өргөдлийн дагуу эмийн эмчилгээг зохицуулах хорооны хурлаар хэлэлцсэн.<br><br>3. Бусад хэсэгт орсон 36 гомдлын 9 буюу 5.8% нь үндэслэлгүй гомдол гэж үзсэн. Үлдсэн 27 гомдол буюу 17.6% нь утсаар цаг авахтай холбоотой, тусламж үйлчилгээний товлосон цагаас өмнө үзүүлэх сонирхолтой хүмүүсийн гаргасан гомдол, эмнэлгийн зогсоолын төлбөртэй ба энэ авто зогсоол нь Улсын хоёрдугаар төв эмнэлэгт харъяалагдахгүй. Нийслэлийн автозамын хөгжлийн газарт гэрээтэй "Дэвжих ган хаш" ХХК авто зогсоолын мөнгийг хурааж авдаг. Холбогдох байгууллагуудад нь удаа дараа албан бичиг хүргүүлсэн болно. Үйчлүүлэгчдэд тухай бүрт утсаар холбогдож тайлбарлаж өгсөн.<br><br>4. Харилцаа, хандлагын талаар ирсэн 16 буюу 10.5% нь тухайн ажилтан, холбогдох тасгийн эрхлэгч нартай биечлэн уулзан сануулга өгөх, анхааруулга өгөх, эвлэрүүлэн зуучлах зэрэг | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байдлаар шийдвэрлэсэн. Эмнэлгийн ажилтны ёс зүйтэй холбоотой ирсэн 6 гомдлыг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд шилжүүлэн тус хорооноос эвлэрүүлэн зуучилсан байна. Долоо хоног бүрийн Мягмар гарагийн хариуцлагатны ярианд эмнэлэгт ирсэн өргөдөл, гомдлыг танилцуулан “Харилцаа, хандлага, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” зэргээр тасаг нэгжүүдэд дотооддоо сургалт зохион байгуулахыг зөвлөсөн. | | | |
| | 56 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/279 тоот тушаалын дагуу албаны нууцын жагсаалт, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн эрүүл мэндийн мэдээлэлд хамаарахгүй хэсгийг ЭМХТ-д тогтмол гаргаж өгч, эмнэлгийн цахим хуудсаар ил тод байршуулдаг. | 100 | | |
| | 57 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Олон нийтийн арга хэмжээ бүх төрлийн нээлттэй хөтөлбөрийг тухай бүрт нь эмнэлгийн цахим хуудсаар болон фейсбүүк пейж хуудсаар дамжуулан мэдээллэж байна. www.ssch.gov.mn | 100 | | |
| | 58 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | https://info.shilendans.gov.mn/ “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан.<br><br>2023 онд нийт 54 ажлын байранд давхардсан тоогоор 145 удаа сонгон шалгаруулах зарыг эмнэлгийн вэб хуудас, эмнэлгийн фейсбүүк фейжд ил тод байршуулсан. 2023 онд нийт 146 ажилтныг сонгон шалгаруулж, шинээр ажилд авсан. Үүнээс 36 эмч, 55 сувилагч, туслах сувилагч, 24 үйлчлэгч, 31 бусад ажилтнууд байна | 100 | | |
| | 59 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам” шинэчлэн батлаж, мөрдөн ажиллаж байна. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Журмыг эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулсан. | | | |
| | 60 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Эмнэлгийн ажилтнуудын харилцаа, хандлагыг сайжруулах ажлын хүрээнд харилцаа хандлагатай холбоотой гомдлын мэдээллийг 7 хоног бүрийн Мягмар гарагийн хариуцлагатаныярианд мэдээлж, дахин давтагдахаас сэргийлж ажилладаг. Эмнэлгийн сувилахуйн алба ЭМЕЗСХороо хамтран дараах ёс зүйн сургалтыг явуулсан. Амьдралд суурилж суралцахуй ТББ-д Сувилахуйн албаны (Ёс зүйн салбар хороо)-ны зүгээс 1 багц цагийн эмнэлгийн мэргэжилтний Ёс зүй-Харилцаа хандлагын сургалтыг 2023 оны 02 дугаар сарын 14-ний 14.00 цагт ҮОЭТ-ийн хурлын танхимд АШУҮИС-ийн БАС-ийн тэнхимийн багш С.Наранчимэг (АУ-ны доктор, профессор), С.Нармандах (докторант) нартай хамтран зохион байгуулж нийт 124 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан. Сургалтын үр дүнд эмч, сувилагч, эмнэлгийн ажилтууд биеэ авч яваа байдал, өөрийн бодол, биеийн хэлэмж, үгийн сонгол, дууны өнгөөс сэтгэлээсээ хандаж буй эсэхэд анхаарах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид хэрхэн яаж хүрэх зэргээр дадлага, онол хосолсон сургалт боллоо.<br>Эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд болон ажилтгнуудад “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж” сэдэвт 2 багц цагийн сургалтын удирдамжийг Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хяналтын хорооны дарга, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөр батлуулан эмч, эм зүйч нарт 2023 оны 11 дүгээр сарын 10-нд зохион байгуулж 194 эмч, эм зүйч нар хамрагдсан.<br>“Байгууллагын соёл”, Эмнэлгийн ажилтны харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүтээмж” сэдэвт 2 багц цагийн сургалтын сувилагч, дэмжих үйлчилгээний ажилтнуудад 2023 оны 11 дүгээр сарын 23-нд 150 сувилагч, ажилтнууд хамрагдсан. | | | | |
| | 61 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Эмнэлгийн албан ёсны цахим хуудасны (www.ssch.gov.mn) “Ил тод байдал” хэсгийн “Хүний нөөцийн ил тод байдал хэсэгт Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж (хуульчилсан акт) дүрэм, журам, заавар жагсаалт, байгууллагын ил тод байдлын тайланг байршуулсан. | 100 | | |
| | 62 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/396 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Мэдээллийн ил тод байдлыг хангах журам”-ыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны А/28 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. | 100 | | |
| | 63 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Эмнэлгийн алба, төв, тасаг, хэсгийн дарга, эрхлэгчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн аргачлалаар хангах, удирдах албан тушаалтны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор “Эмнэлзүйн төв, алба, тасгийн дарга, эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”, “Дэмжих алба, тасгийн эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг тус тус баталж, 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна. | 100 | | |
| | | | мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүссэн тохиолдолд нийтээр тэмдэглэх баярыг тэмдэглэхгүй байх, бусад олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байх тухай эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх, энэ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан өргөн мэдүүлэх. | зохион байгуулахыг багасгаж уөөн бүлгийн болон багийн үйл ажиллагаа, зорилтот бүлэгт чиглэсэн сургалтыг зохион байгуулж байна. Танхмийн сургалт зохион байгуулах үед халдвараас сэргийлэх дэглэм болон нөхцөлийг бүрдүүлж сургалт явуулах талаар зөвлөмж өгч байна.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар шинээр ажилд орсон ХҮН-ийн 10 үйлчлэгч, АХТ-ийн 2 ариутгагч, УЭТ-ийн 1 ажилтан, СЗЭний 2 эрүүл мэндийн ажилтан, ХШТ-ын 2 үйлчлэгч, МЭЭТ-ийн 2 туслах сувилагч, ЕМЗТ-ын 2 туслах сувилагч, Дурангийн төвийн 1 сувилагчид 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх сэдвээр сургалт зохион байгуулсан. Мөн 2022 оны 6 дугаар сараас 2023 оны 5 сар хүртэлх шинээр орсон эмч, эрүүл мэндийн ажилтны дунд халдвараас сэргийлэх хяналт, IPSG 6 зорилтын талаар сургалт 2023 оны 04 дүгээр сарын 25, 27, 05 дугаар сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 70 шинээр орсон эрүүл мэндийн ажилтанд сургалт хийсэн. Нийт алба тасаг нэгжийн 225 эрүүл мэндийн ажилтан сургалтанд хамрагдсан байна. | | | |
| 33 | 151 | Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар 2022 №06 БСШУСБХ | 1.1/. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хамгаалах арга хэмжээ авах; | Эмнэлгийн цахим хуудсаар дамжуулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавар, электрон тамхины хор нөлөөний талаар иргэдэд “Эмч зөвлөж байна” цуврал эрүүл мэндийг зөвлөгөөг хүргэлээ.<br><br>***Эмнэлгийн веб сайтын холбоос:***<br><br>http://www.ssch.gov.mn/mn<br>***Тамхи ба сэтгэлзүй зөвлөгөөний холбоос:***<br>https://ssch.gov.mn/articles/show/tamhi-ba-setgel-z-j/mn | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 154 | | 1.4/. хүүхдэд үйлчилдэг болон хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг байгууллагыг тамхигүй орчин болгох, дам тамхидалтаас сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Тамхины хяналтын хуулийн 9 зүйлд зааснаар Эмнэлгийн ажилчдын хүүхдийн цэцэрлэг, хүүхдийн тасгийн гадна талбайн 100 метрийн ойр орчимд утаат тамхи татахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээг байршуулсан. | 100 | | |
| 34 | 156 | Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ | 1.10. Ахмад настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг (оношлогоо, эмчилгээний нэр төрөл, өрөө тасалгааны тоо хүртээмж, мэргэшсэн эмч, мэргэжилтний тоо) нэмэгдүүлэх; | 2022 оны 10 дугаар сарын 25-нд Хөдөлмөрийн баатар, 80-с дээш насны ахмад настан болон эмнэлгээс тэтгэвэрт гарсан ахмад настанд хүлээгдэл, дараалалгүй, хүртээмжтэй үйлчлэх, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор Дотрын 2 гэсэн кабинетийн үйл ажиллагааг эхлүүлж, нэг эмч томилон ажиллуулж байна. 2023 онд тухайн кабинетаар 714 хүн үйлчлүүлсэн байна. | 100 | | |
| | 157 | | 1.11. Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны хамтын ажиллагааг эрчимжүүлэх. | Ахмад настанд эрүүл мэдний тусламж, үйлчилгээ үзүүлэх кабинетийг шинээр зохион байгуулж, нийт тус кабинетаар 615 ахмад настан үйлчлүүлсэн. | 100 | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 36 | 159 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019_60 | 3. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр болон Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг хангаж ажиллах. | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ нь 2023 онд 3 зорилтын хүрээнд 10 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаа. Эмнэлгийн цахим хуудсаар дамжуулан Эрүүл Мэндийн Яам, Эх, Хүүхдийн Үндэсний Төв, Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв гэсэн эрүүл мэндийн байгууллагаас осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр гаргасан зөвлөмж мэдээллийг цаг тухай бүрд нийтлэн цааш түгээн ажилласан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 160 | | 8. Хар тамхи, мансууруулах бодисоор өсвөр, залуу үеийг хордуулж байгаа нөхцөл байдлыг судлан, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг иргүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тусгах | Нэгдсэн үндэсний байгууллагаас жил бүрийн 6 дугаар сарын 26-ныг "Хар тамхитай тэмцэх" өдөр болгосонтой холбоотой 6 дугаар сарын 23, 27-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх хэлтэс, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч мэргэжилтнүүдтэй хийсэн сургалт зохион байгуулан, хүүхэд залуучуудыг эдгээр хорт бодисоос урьдчилан сэргийлэх, эмнэлгийн нөхцөлд гарч болох эрсдлээс сэргийлэх, арга хэмжээг хэрхэн авах, тохиолдлууд дээр хэлэлцэж, мөн эмнэлэгт мөрдөгддөг "Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг хүлээн авах, олгох, хэрэглэх, хадгалах, бүртгэл хөтлөх, устгах тухай" эмнэлэгт журмын хэрэгжилтэнд хяналт хийн, эмч нарын хэрэглээнд хяналт хийхэд анхан шатны бүртгэл хөтлөлт сайн, эмийн хэрэглээ, эмчийн жор бичилт дээр сул байсан тул сургалт, арга хэмжээ зохион байгуулан ажилласан. Мөн эмийн хадгалалт тасаг нэгжүүдэд харилцан адилгүй, аюулгүй байдал, алдагдах эрсдэл өөр өөр байсныг мэдээллэсэн. Тиймээс эрсдлээс сэргийлэх арга хэмжээг авч бүрэн камержуулахаар тендер зарлагдан худалдан авалт хийхээр ажиллаж байна. | 100 | | |
| 37 | 163 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 1.14.. Эмийн худалдаа, чанар, хадгалалт, эргэлтэд тавих хяналтыг чангатгах. | Эм, эмнэлгийн хэрэгслийн оношлуур худалдан авах УХТЭ/202302001 дугаартай тендер шалгаруулалтыг ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ хуулийн дагуу нээлттэй 4 удаа тендер шалгаруулалт зохион байгуулан 78.3%-тай, Өндөр өртөгтэй тусламж үйлчилгээнд хэрэглэх эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопед худалдан авах УХТЭ/202302002 дугаартай тендер шалгаруулалыг мөн хуулийн дагуу шалгаруулалт явуулан 97.2%-тай тус тус зохион байгуулан, | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шууд гэрээ байгуудлах шат дээрээ үлдсэн тендерийг үнэлэхээр ажиллаж байна.<br>Тендерт орсон эм, эмнэлгийн хэрэгсэлийг ЭЭХХЗГ-н http://www.druginfo.mohs.mn линкийг ашиглан, улсын бүртгэлийг шалгадаг. Мөн эм, эмнэлгийн хэрэгслийн эргэлтэд хяналт тавихаар тендерт шалгарсан байгууллагуудаас ирсэн дээжийг каталоги болгон үйл ажиллагаандаа ашиглан, хуурамч эм, эмнэлгийн хэрэгсэл орж ирэхээс сэргийлэн ажиллаж байна.<br>Эм эмнэлгийн хэрэгсэлд чанарын хяналт тавихдаа албаны чанарын баг хуваарийн дагуу бусад тасгийн (хөндлөнгийн) хянагчаар эмч, сувилагчдыг нөөцийн хэсгийн эм, эмнэлгийн хэрэгсэлд аудит хийлгэдэг. Хэвтэн эмчлүүлэх тасаг нэгжүүд дэх яаралтай тусламжийн тэргэнцэр болон шүүгээ саван дахь эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хадгалалт, хэрэглээнд эм зүйч нар эмнэлгийн дотоод журмын дагуу хяналт хийдэг. | | | |
| 38 | 165 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/ 2020-02-12 Дугаар 2020_10 | 1. 1. Дэлхийн олон улс болон манай хөрш БНХАУ-д шинэ коронавирусийн тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл болгосугай: 1.1. Шинэ коронавирусийн тархалтын нөхцөл байдалтай уялдуулан хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 | Эмнэлэгт амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ авах үед үйлчлүүлэгчийг заавал дархлаажуулалтанд хамрагдсан байх гэдэг шалгуур тавигдаагүй. Эмнэлэг дээр цар тахлын үед болон халдварын дэгдэлтийн үед баримтлах түр зааврыг 2023 онд 2 удаа шинэчлэн гаргаж хэрэгжүүлсэн. Шинэчлэн гаргасан түр зааврыг эрүүл мэндийн ажилтнуудад цахимаар хүргүүлсэн. 2023 онд Короновируст халдварын батлагдсан тохиолдол нийт үйлчлүүлэгчдээс 16, эрүүл мэндийн ажилтнаас 6 тохиолдол батлагдсан байна.<br>Хүүхдийн тасгийн томуу томуу төст өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний 3 бүлэг 26 үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж цахимаар холбогдох мэргэжилтүүдэд мэдээлсэн. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэглэлийг үе шаттайгаар сонгон хэрэгжүүлэх шийдвэр гаргах; 1.2. Олон улсын хөл хориот болон халдварт бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин гарсан үед тархаахгүй байх, таслан зогсоох зорилгоор хорио цээрийн дэглэм тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар яаралтай хэлэлцэн журамлаж, мөрдүүлэх; 1.3. Цагаан сарын баярт зориулсан олон нийтийг хамруулсан үзэсгэлэн худалдаа, мэдээллийн хэрэгслээр явуулах реклам, сурталчилгааг даруй зогсоох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх иргэдийн үүрэг, хариуцлага, уг халдварын хор хөнөөлийг ухуулан ойлгуулах ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах; 1.4. Дэлхий дахинд хүнээс хүнд, мал, амьтнаас хүнд халдварлах халдварт өвчин ихээр тархах болсонтой холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай болон бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох хууль | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулган, шаардлагатай бол ээлжит бус чуулганаар яаралтай горимоор хэлэлцүүлэх. 2. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүргээ ухамсарлан, өөрийн болон нийтийн эрх ашгийг эрхэмлэхийг нийт ард иргэдэд уриалсугай. | | | | |
| 39 | 166 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд: 2023 оны Хаврын мод тарих үндэсний өдрүүдийг “Ногоон хот-Иргэний оролцоо” уриатай зохион байгуулж байгаа. Хаврын мод тарих ажилд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хамт олон нэгдэж үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хуваарьт газраа улиас, шар хуайс зэрэг 25 модыг суулгасан. | 100 | | |
| 40 | 169 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.7. Хорт зуршлаас ангид шинэ үеийг төлөвшүүлэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт архи, согтууруулах ундаа, түүнээс үүдэн гарах хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах агуулгыг тусгах; | Эмнэлгийн албан ёсны веб хуудсанд “Эмчийн зөвлөгөө “Эрүүл мэндийн цэс” үүсгэн эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг тогтмол оруулаж байна.<br>Иргэд, олон нийтэд архи, согтууруулах ундаа, түүнээс үүдэн гарах хор уршиг, сөрөг нөлөөний талаар цуврал эрүүл мэндийг зөвлөгөө мэдээллийг иргэдэд олгосон.<br>***Зөвлөгөө мэдээлэл:***<br>•Архины тухай түгээмэл буруу ойлголтууд<br>•Архины хор хөнөөл<br>•Архи ба зүрх судасны өвчин<br>***Эмнэлгийн веб сайтын холбоос:***<br>http://www.ssch.gov.mn/mn<br>***Эмчийн зөвлөгөө, мэдээллийн цэсний холбоос:*** | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | http://www.ssch.gov.mn/articles/mn?order=date&orderdir=desc&p=9&page=4 | | | |
| | 170 | | 2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай. | Архи согтууруулах ундааны хэрэглээний хор уршгийг олон нийтэд таниулах зорилгоор Эмнэлгийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд “Эмч зөвлөж байна” цуврал эрүүл мэндийг зөвлөгөөг хүргэлээ.<br>***Эмнэлгийн веб сайтын холбоос:***<br>http://www.ssch.gov.mn/mn<br>***Эмчийн зөвлөгөө, мэдээллийн цэсний холбоос:***<br>http://www.ssch.gov.mn/articles/mn?order=date&orderdir=desc&p=9&page=4<br>***Зөвлөгөө мэдээлэл:***<br>•Архины тухай түгээмэл буруу ойлголтууд<br>•Архины хор хөнөөл<br>•Архи ба зүрх судасны өвчин | 100 | | |
| 41 | 172 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159 | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 14:00 цагаас 18:00 цаг хүртэл Нийслэлийн 1 дүгээр сургуулийн ахлах ангийн 50 сурагч хими, биологийн багш Болорцэцэгийн хамт эмнэлгийн захирлын баталсан төлөвлөгөөний дагуу танилцах аялал хийсэн.<br><br>Сурагчдад зориулж эмнэлгийн зориулалтын дүрэмт хувцас болох эмнэлгийн лого бүхий цагаан халад өмсүүлж эмнэлгийн гадна үүдэн хэсэгт удирдлагын баг, хариуцсан багш болон тасгийн эрхлэгч нар сурагчидтай дурсгалын зураг авахуулсан.<br><br>Эмнэлгийн хурлын зааланд эмнэлгийн удирдлагын багийн гишүүд хүлээн авч уулзсан ба эмнэлгийн ерөнхий захирал, АУ-ны доктор, дэд профессор Б.Эрдэнэбулган танилцуулга хийж илтгэл тавьсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Танилцах аялалын хүрээнд Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн цахим бүртгэл, Цөмийн оношилгоо эмчилгээний төв, Радиологийн тасаг, Яаралтай тусламжийн тасаг, Нэгдсэн лабораторийн тасаг, Ангиографийн тасаг, Дурангийн төв, Ерөнхий мэс засал судлалын тасгаар орж тухайн тасагт хийгддэг онцлог ажилбар, үйл ажиллагааны талаар мэдээлэл авсан. Тасгийн эрхлэгч, төвийн дарга нар сурагчдад зориулан мэдээлэл бэлтгэж тасгаараа орж танилцуулсан. Тасаг бүр өөрийн үйл ажиллагааны онцлог болон сурагчдад тохируулан микроскопт харуулах, ажилбар харуулах, дурангийн дасгал ажлын муляж дээр ажиллуулах, видио үзүүлэх зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулсан.<br><br>Сурагчдыг А,Б,В,Г гэсэн 4 багт хувааж 4 эмчээр ахлуулан тасгуудаар танилцуулсан. А багийн ахлагчаар сургалт гадаад харилцааны албаны дарга Д.Цэнджав, Б багийн ахлагчаар халдвар судлаач эмч Ц.Уянга, В багийн ахлагчаар Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч Ж.Уламсайхан, Г багийн ахлагчаар ЭМТҮЧАБА-ны чанарын менежер Б.Дулмаа нар ажиллаж 8 тасгаар өртөөлөн аялсан. 4 баг 4 өөр өнгийн тугаа барин тасгуудаар өртөөлөн аялсан нь сурагчдад сонирхолтой байсан.<br><br>Цахим бүртгэлийн хэсэгтэй танилцаж Хоол шим тэжээлийн тасгаар үйлчлүүлж иж бүрдэл хоол шүүсээр үйлчлүүлсэн.<br><br>Эмнэлэгтэй танилцах аяллын үйл ажиллагааны талаар эмнэлгийн цахим хуудсанд дараах | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | линкээр орно. https://fb.watch/jrMzUT5TJ8/?mibextid=l2pjGR<br><br>arslan.mn, MNB сувгаар мэдээлэл дамжуулсан.<br><br>"Сурагчдыг эрүүл мэндийн боловсрол олгох сургалт" сэдвээр Нийслэлийн ерөнхий боловсролын нэгдүгээр сургуультай хамтран тус сургууль дээр сургалтыг 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих эрүүл ирээдүйг бүтээх зорилгоор ЭМЯ-ны Дэмжих сангийн төслийн санхүүжилтээр эмнэлгийн 7 эмч мэрэгжилтэн, Чанарын менежерийн мэргэшүүлэх сургалтын резидент 4 эмч, АШУҮИС-ын Нүүр амны гажиг заслын тэнхмийн резидент 11 эмч нар мэдээлэл өгсөн. Нийслэлийн ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн бага ангийн 1-5 ангийн 26 хүүхдэд АШУҮИС-ын Нүүр амны гажиг заслын тэнхмийн резидент эмч нар Амны хөндийн эрүүл мэндийн эрүүл ахуйн сэдвээр 1300 хүүхдэд сургалт хийсэн.<br><br>Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ажилтан болон чанарын менежерийн мэргэшүүлэх сургалтын резидент эмч нар 6-9 ангийн буюу дунд ангийн хүүхдүүдэд Цусаар дамжих халдварын эрсдэл, шивээс зэргийн талаар сургалт орсон бол эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эмч Ц.Сэвжид болон бөөрний мэс заслын тасгийн эмч Ө.Золбоо нар 9-12 ангийн хүүхдүүдэд “Бэлгийн боловсролын талаар сургалт хийсэн бөгөөд нийт 1950 хүүхдэд сургалт орсон байна. | | | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | | |
| 42 | 173 | Халдварт өвчний өнөөгийн | 1. 1. "Дархлаажуулалтын тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан | 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр "Хайртай хүмүүсээ элэгний халдвараас хамгаалцгаая" аян зохион байгуулж нийт эрүүл мэндийн ажилтны гэр | 100 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдал, хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2010-03-19 Дугаар 2010_11/06 | авах бараа, ажил, үйлчилгээний тухай", "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, вакцины нийлүүлэлт, эм, хүнсний зохицуулалтын бие даасан алба байгуулах, хөндлөнгийн хяналтыг тодорхой болгох, зарим эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцин тоног төхөөрөмжийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрээс шууд худалдан авах бололцоог бүрдүүлэх, улсын хэмжээнд вакцин, биобэлдмэлийн хөндлөнгийн хяналтын лаборатори байгуулах, төрийн хяналтыг чангатгах, хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх, | бүлийнхэнийг вакцинжуулан 2023 оны 02 дугаар сарын 15,16 өдрүүдэд ЭТҮГЭН их сургууль Олон улсын улаанбаатар их сургуулийн сувилахуйн чиглэлээр суралцаж буй 40 оюутанд В гепатитын дархлаа тогтоцыг 32 оюутанд нэмэлт дархлаажуулалтыг хийсэн. 2023 оны 11 сард эрүүл мэндийн ажилтан болон резидент эмч нарыг оролцуулан 600 хүнийг томуугийн дархлаажуулалтанд хамруулсан. Ордны эмнэлгийн тусламж үйлчилгээний цэгээр дамжуулан 250 хүнийг томуугийн дархлаажуулалтанд хамруулсан.<br>ЭМС-ийн 02 тоот албан даалгаварын хүрээнд сувилахуйн албатай хамтран нийт 14 вакцинатор сувилагч "Аюулгүй дархлаажуулалт" сургалтыг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. ЭМС-ын 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 5/1616 чиглэл хүргүүлэх талаар АХТ-ийн 16 ариутгагч угаагч нарыг халдвараас сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулсан.<br>Халдвараас сэргийлэх талаар видео шторк, анимейшны ажил гүйцэтгүүлэх гэрээг 2023 оны 03 дугаар сарын 29 өдөр "Хурд инженеринг" ХХК Irmuun Z production-тай хийгдэж 6 төрлийн 10.97 минутын бичлэг хийгдсэн. Нийт 6 бичлэг 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл зураг авалтын ажил хийгдэж дууссан. 11 дүгээр сарын 10 өдөр бичлэг бэлэн болж хүлээн авсан. Бичлэг сэдэв 1. Мэс заслын аюулгүй байдал (02:45 мин) 2. Эмнэлэгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг бууруулах (02:11 мин) 3. Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдал (01:52 мин) 4.Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах (01:32 мин) 5. Үр дүнтэй харилцаа (02:08 мин) 6. Унах эрсдэл (01:52 мин) 7. Хөгжмийн булан (02:05 мин) бичлэгийг хүлээн авсан. Мэдээлэл технолгийн | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | албанд хүргүүлж үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсгүүдэд байршуулсан. 2023 оны байдлаар нийт 232 эрүүл мэндийн ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд В гепатитийн дархлаа тогтцын шинжилгээнд хамрагдаж давтан тунгаар дархлаажуулсан. | | | |
| 45 | 186 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05 | 1.2. Мансуурулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээ, гааль, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагын саналыг авч НҮБ болон ДЭМБ-аас гаргсан жагсаалтыг үндэслэн тухай бүр шинэчлэн батлах санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх | Эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/53 дугаар тушаалаар томилогдсон Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөд бодисын эргэлтэд тавих хяналтыг эрчимжүүлэх, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах зорилготой Ажлын хэсэг, ЭМТҮЧАБ-ын албатай хамтран 05 дугаар сарын 4, 5, 9, 12-ны өдрүүдэд хяналт хийсэн. Дотоод хяналт хийсэн чиглэл: Мансууруулах ба сэтгэцэд нөлөөт эмийн орлого, зарцуулалт, хадгалалт, хэрэглээ, хууль журамд нийцэж байгаа эсэхэд: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Засгийн газрын тогтоол “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 196 дугаар, ЭМС-ын 2015 оны А/68 дугаар тушаал “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханан нийлүүлэх журам”, УХТЭ-ийн “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг хүлээн авах, олгох, хэрэглэх, хадгалах, бүртгэл хөтлөх, устгах тухай” журмын хэрэгжилтэд Хамрагдсан тасаг, нэгж: МЭЭТ, ЕМЗТ, ГСОМЗТ, Шигдээсийн нэгж, Ангиографийн тасаг, МСТ, ХБЭСТ, ЗССТ, БДШБСТ, Тусгай тасаг, ЯТТ, Хүүхдийн тасаг, Дурангийн төв, Харвалтын нэгж<br>Хяналт үнэлгээгээр нийтлэг 6 үл тохирол илэрсэн. Хяналт үнэлгээний тайланд 6 зөвлөмж гарч тасаг нэгжүүдэд өгсөн. Хяналт үнэлгээний тайланг эмнэлгийн Ерөнхий захиралд өгсөн. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 46 | 188 | Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03 | 6. . Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга) | Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран анх удаагаа Улаанбаатар хотын хэмжээнд газар хөдлөлтийн үзүүлэх сургуулиалт зохион байгуулж байгаа Стратегийн команд штабын сургуулийн хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр 16 цагт орон даяар гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулсан. Мөн эмнэлгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж Баянзүрх дүүргийн онцгой байдлын хэлтэсийн орлогч дарга, хошууч Э.Энхбаяраар хянуулан батлуулсан. | 100 | | |
| Засгийн газрын тогтоол | | | | | | | |
| 50 | 193 | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 | 3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | Эмнэлгийн хог хаягдал болон хоол үйлдвэрлэл, цэвэрлэгээ үйлчилгээ, угаалга, харуул хамгаалалт зэрэг ажлуудыг бусдаар гүйцэтгүүлэх шаардлагын дагуу тооцоо судалгааны ажлууд хийгдэж байгаа. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2022_340 | | | | | |
| 54 | 197 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 | 5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | 2023 онд тус эмнэлгийн нийт 14 сувилагч Өвөрхангай, Сэлэнгэ, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий, Хэнтий, Дорнод, Архангай, Сүхбаатар, Өмнөговь, Хөвсгөл аймагт сувилагч мэргэжлээрээ ажиллаж, амьдрахаар шилжлээ. | 100 | | |
| 56 | 200 | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448 | 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг | Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна. Тэвчиж болох зардлуудыг гаргаагүй болно. https://info.shilendans.gov.mn/ReportFormSettings/ReportOrganizationData | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 61 | 207 | 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр 19 дүгээр | II.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй дуусаагүй, олон жил үргэлжилж, хэрэгжилт нь удааширч байгаа төсөл, арга хэмжээний | Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дэргэдэх МОН-8 төслийн хүрээнд хэрэгжиж буй Эмч хөгжлийн төвийн барилгын ажлын явц 70%-тай барилгын явц удааширсан шалтгаан нь ковид-19 цар тахал | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэмдэглэл 2021-03-24 Дугаар 2021_19 | шалтгаан нөхцөлийг мэргэжлийн байгууллагатай хамтран нягтлан тогтоож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | гарсантай холбоотой. Одоо барилгын ажил зогссон байна.<br>Үндэсний оношилгоо эмчилгээний төв байрны дэргэдэх цогцос хадгалах байрны ажлын явц 90%-тай зогссон. Барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комисс ажилласан боловч шаардлага хангаагүй тул хугацаат үүрэг даалгаврыг гүйцэтгэгч байгууллага болох ЖҮЖҮ ХХК-д өгсөн. | | | |
| 65 | 212 | 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдөр 46 дугаар тэмдэглэл 2021-08-11 Дугаар 2021_46 | XYII.7. . Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн ажлын явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Цахим шилжилтийн асуудлаар Эстони Улсын туршлага, жишиг загварыг ашиглах боломжийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт даалгав. | Эмнэлгийн амбулатори болон дүрс оношилгоо, лаборатори, өвчтөний түүх нь бүрэн цахим хэлбэрт шилжсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн дагуу бүх дата болон серверүүд нь үндэсний дата төвд байршдаг. Эрүүл мэндийн сайдын тушаал болон Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01 тоот тогтоолын дагуу програм хангамж дээр тогтмол өөрчлөлт шинэчлэлтийг хийж дуусгасан. Эмнэлгийн лист буюу хөдөлмөрийн чадвараа түр алдсаны хуудас нь бүрэн цахим хэлбэрт шилжсэн. 13а маягт бүрэн цахим болсон. | 100 | | |
| 66 | 213 | 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2021-08-25 Дугаар 2021_48 | XYI.4. . Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамруулах арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 15-ны А/139 тоот тушаалын дагуу “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ын нийт 5659 хүнд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Үүнээс өвчлөлийн бүтцээр нь:<br>1. Зүрх судас-Зүрхний даралт ихсэх өвчин , Ишеми, Хэм алдагдал | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав. | 2. Уушги-Архаг бронхит, Астма, Уушгины бусад тодорхой өвчин<br>3. Хоол боловсруулах эрхтэн судлал-Ходоод улаан хоолойн сөөргөө, Архаг гастрит, Биж хам шинж<br>4. Дотоод шүүрэл булчирхай судлал-Чихрийн шижин хэв шинж 2, Бусад хордлогогүй бахуу<br>5. Бөөр-Шээсний замын тодорхойгүй байршилт халдвар, Сувганцрын завсрын эдийн архаг нефрит,Бөөрний олдмол уйланхай<br>6. Цус судлал-Хоёрдогч полицетими, Липопротеины солилцооны ба цус өөхжих бусад хямрал, Цус багадал, тодорхойгүй<br>1.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдол болон ашиг тусыг нь тухайн эмнэлгийн цахим орчинд мэдээлэл хүргэсэн.<br>2.Байгууллагаар нь нэгдсэн байдлаар зохион байгуулах. Тухайн байгууллагад мэдээлэл өгч хамтран ажиллах.<br>3.18-34 насны бүлгийн даатгалаа төлсөн иргэдийн үзлэгийн тоог нэмсэн.<br>4.Эрүүл мэндийн даатгал төлдөг байгууллагууд болон тэтгэврийн насны болон групп, халамжид байгаа бүлэг рүү үзлэг хийх ажил зохион байгуулсан.<br>5.Эрүүл мэндийн даатгал төлөлтийн ажлыг Этүгэн их сургуулийн 1-3 курс болон Олон улсын Улаанбаатар их сургуулийн 1-3 курсийн оюутнуудын эрүүл мэндийн даатгал төлүүлж урьдчилан сэргийлэх үзлэгийг сувилахуйн албатай хамтран зохион байгуулсан. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | 216 | 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55 | XY.6.2. Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын хэрэгцээнд ашиглагдаж байгаа 2014 оноос өмнө худалдан авсан 196 автомашин, сумдын эмнэлгийн үйлчилгээний 98 автомашиныг ашиглалтын зохих норм норматив, стандартыг харгалзан үе шаттайгаар шинэчлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; | Эмнэлгийн зориулалттай 6, суудлын 2, ажилчдын автобус 1 буюу эмнэлгийн хэрэгцээнд нийт 9 тээврийн хэрэгслийг норм, журмын дагуу ашиглаж байна. | 100 | | |
| 73 | 220 | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 | XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | 2023 онд дуудлагын төвтэй болсоноор 70150222 дугаарын утсаар нийт 28,764 үйлчлүүлэгчид үзлэгийн цаг авах, мэдээлэл өгөх зэрэг үйлчилгээ үзүүлсэн байна. Нийт 3685 үйлчлүүлэгчид E-mail хаягаар шинжилгээний хариу илгээсэн байна. E Mongolia системээр цаг захиалах модулийн шинэчилэгдсэн хөгжүүлэлтийг хийж дуусгасан. | 100 | МТА | |
| 74 | 221 | 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар | IX.8. . Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт | 2023 оны 01 дүгээр сарын 04-өөс 2023 оны 01 дүгээр сарын 20-ны хооронд Кангбунг Самсунг эмнэлгийн Эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх төвд сургалтанд Эрүүл мэндийг дэмжих төвийн 2 эмч, Эрүүл мэндийн даатгалын 1 эмч БНСУ-д | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэмдэглэл 2022-03-23 Дугаар 2022_17 | илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг орон даяар зохион байгуулах бэлтгэл ажлын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, уг үйл ажиллагааг иргэдэд чирэгдэлгүй, чанартай, эрсдэлгүй, хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, шаардлагатай гэж үзвэл бусад улсын туршлага, жишиг загварыг ашиглах боломжийг судлахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод тус тус даалгав; | туршлага судлах болон олон шинэ туршлагаас нь суралцан ирсэн. Үүний дагуу урьдчилан сэргийлэх төвийн урсгал, хаягжилт болон шинээр үзлэгийн дүгнэлт боловсруулах, үйлчлүүлэгчид ээлтэй, эрсдэлгүй, чанартай тусламж үзүүлэхээр ажиллаж байна. | | | |
| | 222 | | IX.8.2. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг нийгмийн халамжийн үйл ажиллагаатай уялдуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд судалж, зохих арга хэмжээ авахыг Хөдөлмөр, | Улаанбаатар болон Этүгэн сургуулийн оюутнуудад чиглэсэн өвчнөөс урьдчилан сэргийлэх ач холбогдлыг талаар сургалт хийж. Эрт илрүүлэгт даатгалаа төлсөн оюутныг үзлэгт хамруулсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав. | | | | |
| 75 | 224 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж байгаатай холбоотой байгууллагын ажилтнуудад ажлын байр дээр ирж тоон гарын үсэг үүсгэх үйл ажиллагааг эмнэлгийн захиргаанаас 2022 оны 05 дугаар сарын сарын 30,31-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн байцаагчтай хамтарч 302 ажилтан, 2023 оны 03 сарын 10-ны өдөр Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн байцаагчтай хамтарч 190 ажилтан, нийт 492 ажилтныг цахим гарын үсэгтэй болгосон. | 100 | | |
| 82 | 235 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл | XY.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 15-ны А/139 тоот тушаалын дагуу “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”- | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022-08-24 Дугаар 2022_42 | оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | н дагуу Архангай аймгийн Эрдэнэ мандал сумын Эрүүл мэндийн төвийн ажилчид, Ховд аймгийн Буянт сумын сургууль, цэцэрлэгийн багш нар орсон. Орхон аймаг, Дорнод аймгийн эрүүл мэндийн ажилтан болон Эрүүл мэндийг дэмжих төвийн ажилчдад эмнэлгийн эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагаа болон үзлэгийн явцыг танилцуулсан.<br>Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/256 дугаар “Эрт илрүүлэг, шинжилгээ, оношилгоог эрчимжүүлэх тухай” тушаалын дагуу Эмнэлгийн явуулын үзлэгийн баг Архангай-459, Өвөрхангай-1619, Баянхонгор-1661, Төв-778, Ховд-230, Говь-Алтай-780 аймагт эрт илрүүлгийн үзлэг хийсэн. Нийт үзлэгийн 5527 хүнд багаар тусламж үзүүлсэн. Үүнээс Өвөрхангай, Ховд аймаг эрт илрүүлгийн санхүүжилтээ аваад байна. | | | |
| 84 | 237 | 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49 | XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав. | Үндэсний дата төвд Эмнэлгийн 22 сервер, 1 Backbone switch, 1 Tape Library, 1 Firewall, 1 KVM swtich, 2 SAN Switch, 1 NETGEAR 24P Switch зэрэг тоног төхөөрөмжийг “AXIS Systems” ХХК-тай хамтран Taihan-ы Солонгос инженерүүдийн тусламжтайгаар угсралт суурилуулалт хийгдсэн. Мөн Үндэсний дата төв Эмнэлэг хооронд “Монголын Цахилгаан Холбоо” ХК-ны 16км шилэн кабелаар холбогдсон. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 88 | 243 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | Тус эмнэлэг нь өөрийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдыг нэгдсэн байдлаар цахим гарын үсэгтэй болгох дараах үйл ажиллагааг явууллаа. Үүнд: 2022 оны 05 дугаар сарын 30,31-ний өдрүүдэд ЧД-ын Улсын бүртгэлийн байцаагчтай хамтарч 302 ажилтан, 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр БГД-ийн Улсын бүртгэлийн байцаагчтай хамтарч 190 ажилтан, нийт 492 ажилтныг цахим гарын үсэгтэй болгосон.”<br>2023 оны 01 дүгээр сараас Эйблсофт ХХК-тай Эйбл системийн ашиглалт, үйлчилгээний гэрээ” байгуулан “Ажил хэргийн програм” эмнэлгийн хэмжээнд нэвтрүүлж, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож байна. | 100 | | |
| Засгийн газрын албан даалгавар | | | | | | | |
| 92 | 247 | Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6 | 1. 1.1. ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацаааны хөгжлийн бодлогын хүрээнд Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн стратеги төлөвлөгөөг гаргаж ЭМЯаманд хүргүүлсэн. Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн байгууллагын эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө зэргийг боловсруулан ажиллаж байна.<br>• Байгууллагын эрхэм зорилго: Монгол улсын иргэдийн эрүүл амьдрах, сэтгэл ханамжийг хангаж ажиллах, үйлчлүүлэгч болон ажилчдын орчны аюулгүй байдлыг хангасан, үйлчлүүлэгч төвтэй цогц үйлчилгээг үзүүлэхийг зорин ажиллаж байна. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | • Үйл ажиллагааны стратегийн зорилго: Олон улсын стандартад нийцсэн, хүлээн зөвшөөрөгдсөн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээтэй холбоотой стандартуудыг нэвтрүүлж хэрэгжүүлсэн батламж авч, Монгол улсын шилдэг эмнэлэг болох, үйлчлүүлэгчдэд Монгол улсын шилдэг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага гэдгээ хүлээн зөвшөөрүүлэх зорилготойгоор ажиллаж байна.<br>• Үйл ажиллагааны стратегийн зорилт: Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь олон улсын магадлан итгэмжлэгдсэн байгууллага болох(JCI), гадаадаас үйлчлүүлэгч хүлээн авах, эмнэлгийн гол үйлчилгээг хөгжүүлэх, шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, эмнэлгийн ажилчдыг олон улсын жишигт нийцүүлэн сургах, мэргэшүүлэх, шаардлага хангасан эмнэлгийн орчин нөхцлийг бүрдүүлэх гэсэн 6 гол зорилт тавин ажиллаж байна.<br>Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ба түүний үр дүн:<br><br>Байгууллагын өнөөгийн тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийснээр, эмнэлгийн цаашдын үр өгөөжтэй ажиллах, байгууллагын хөгжлийн бодлогын хүрээнд шинээр ямар арга хэмжээ, бодлого хэрэгжүүлэх тухай төлөвлөгөө гарган ажилласан.<br>Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийснээр Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эрхлэх асуудал нь нийт 61 хууль байна. Үүнээс: Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах 18 хуулийн хүрээнд салбарын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | SWOT шинжилгээ хийж, дотоод орчны давуу болон сул тал, гадаад орчны эрсдэл, боломжийг дүгнэн шинжилж цаашид хэрэгжүүлэх эрсдэл боломжийн төлөвлөгөөг нарийвчлан тодорхойлсон.<br>Салбар хоорондын хөгжлийн харилцан уялдаа, бодлого үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах арга замыг тодорхойлж, хүрэх үр дүнг тооцсон бөгөөд зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж цаашдын стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | | | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБА